



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 16 өдөр

Дугаар А/167

Хужирт сум

Хоршоог хөгжүүлэх сангаас
зээл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.4.2, 3.4.3, 3.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. "Хоршоог хөгжүүлэх сан"-гийн төсөл сонгон шалгаруулах хорооны 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны шийдвэрийн дагуу шалгарсан нэг төсөлд "Хоршоог хөгжүүлэх сан"-гийн зээлийн эргэн төлөлтөөс төвлөрсөн 20,000,000 (хорин сая) төгрөгийг хавсралтаар олгосугай.

2. Төсөлд олгогдох хөрөнгийг тус сангаас зарцуулж, орлого, зарлагын дүн болон зарцуулалтын тайланг улирал, жилээр гаргаж дүнг танилцуулж байхыг Төсвийн ерөнхий Нягтлан бодогч (Д.Уранчимэг)-д үүрэг болгосугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ДЭМБЭРЭЛ